



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2021 оны 01 сарын 26 өдөр

Дугаар 20

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.б дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020 онд Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын багцаас санхүүжүүлэн барьж ашиглалтад оруулсан нийт 442,998,664.00 /дөрвөн зуун дөчин хоёр сая есөн зуун ерэн найман мянга зургаан зуун жаран дөрвөн/ төгрөгийн үнэ бүхий барилга, байгууламжийг хавсралтад заасны дагуу Хөвсгөл аймгийн орон нутгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Хөвсгөл аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Б.Болд нар тус тус дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хавсралтад заасан үл хөдлөх хөрөнгийг Улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулсан эрх бүхий байгууллагын шийдвэр, тооцоо, гүйцэтгэгчээс захиалагчид хүлээлгэн өгсөн баримт дахь хөрөнгө тус бүрийн задаргаа, зориулалтыг харгалзан, байнгын ашиглалтад хүлээн авч, эзэмшигчийг тогтоож /холбогдох сумдын Засаг даргын Тамгын газарт/ бүртгэх асуудлыг шийдвэрлүүлэх;

2.2. Хөрөнгийг зохих хууль тогтоомж, журмын дагуу няглан бodoх бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

13201013

Төрийн өмчийн бөдлогоо, зохицуулалтын газрын  
2021 оны 01 дугаар сарын 26-ны өдрийн  
Дугаар тогтоолын хавсралт

**Хөвсгөл аймгийн орон нутгийн өмчид бүртгэх үл хөдлөх хөрөнгийн жагсаалт**

Д/А	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Барилгын хучин чадал	Гүйцэтгэлээрх дүн, төгрөгөөр/	Улсын комиссын актын дугаар
1	Ахмадын өргөөний барилга /Хөвсгөл аймаг, Бүрэнтогтох сум/	1 давхар, зооргүй, 120 м2	48,350,390.00	2020-08-11 УКД- 2020/44
2	Ахмадын өргөөний барилга /Хөвсгөл аймаг, Тариалан сум/	1 давхар, зооргүй, 106.9 м2	49,433,331.00	2020-10-08 УКД- 2020/48
3	Ахмадын өргөөний барилга /Хөвсгөл аймаг, Түнэг сум/	1 давхар, зооргүй, 120 м2	49,079,639.00	2020-08-21 УКД- 2020/31
4	Ахмадын өргөөний барилга /Хөвсгөл аймаг, Цагаан-Уул сум/	1 давхар, зооргүй, 120 м2	47,240,762.00	2020-11-21 УКД- 2020/68
5	Ахмадын өргөөний барилга /Хөвсгөл аймаг, Цэцэрлэг сум/	1 давхар, зооргүй, 120 м2	48,894,542.00	2020-11-23 УКД- 2020/65
6	Ахмадын өргөөний барилга /Хөвсгөл аймаг, Төмөрбүлаг сум/худалдан авсан/	2 давхар, зооргүй, 201 м2	200,000,000.00	2020
	<b>Нийт дүн</b>		<b>442,998,664.00</b>	/дөрвөн зуун дөчин хоёр сая есөн зуун ерэн найман мянга зургаан зуун жаран дөрвөн/